



**УЛСЫН НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2009 оны 04 сарын 07 өдөр

Дугаар 131

Улаанбаатар хот

┌ **Журам шинэчлэн батлах тухай** ┐

Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5 дахь заалт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2008 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 20 дугаар тогтоол, Засгийн газрын 1994 оны 171 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийгмийн даатгалын байгууллага, байцаагчийн дүрэм”-ийн 16 дугаар зүйлийн “к” заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын шимтгэл тооцох, төлбөр хийх, тайлагнах журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

Хоёр. Журам батлагдсантай холбогдуулан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын шимтгэлд төлөх хөрөнгийн хэмжээг тооцож, жил бүрийн төсөвт тусган батлуулж байхыг Бодлогын хэрэгжилт, төлөвлөлтийн газар /Ц.Дашдондог/, холбогдох төлбөр, тооцоо хийж, тайлагнаж байхыг Санхүү, бүртгэлийн газар /З.Цэдэнжав/, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, үнэлгээний газар /Ё.Пүрэвцэрэн/-т тус тус үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын дэд дарга /Ж.Эрдэнэбаатар/-д даалгасугай.




ДАРГА



Ч.АЛТАНХУЯГ

249

Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын
даргын 2009 оны 04 дүгээр сарын 07-ны
өдрийн 131 тоот тушаалын хавсралт



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧНИЙ ДААТГАЛЫН САНГААС ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛ ТООЦОХ, ТӨЛБӨР ХИЙХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

1. Энэхүү журмыг Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5 дахь заалт, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2008 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 20 дугаар тогтоолд тус тус заасны дагуу үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа алдан тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа даатгуулагчийн уг тэтгэврийг авч байх хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг тооцох, төлбөр хийх, гүйцэтгэлийг тайлагнахад баримтална.

2. Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар нь үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас тахир дутуугийн тэтгэвэр авч байгаа иргэдийн тоо, тухайн үед мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэврийн даатгалын санд даатгуулагчийн төлөх хувь, хэмжээ /7,0 хувь/ зэргийг үндэслэн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэврийн даатгалын санд төлөх шимтгэлийн хэмжээг тооцон, Нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусган батлуулна. Мөн батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг аймаг, нийслэлийн хэлтэс, газар бүрээр тооцон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлд оруулан батлуулна.

3. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолоор батлагдсан нарийвчилсан хуваарийн дагуу аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын сангийн жил бүрийн төсөвт тусгагдсан хэмжээ, тэтгэвэр авагчдын тоог тусгасан санхүүгийн тайланг баримтлан үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн данснаас энэ журмын 2 дахь хэсэгт заасан тэтгэврийн даатгалын шимтгэлийг тэтгэврийн даатгалын сангийн дансанд шилжүүлж, төлбөрийн гүйцэтгэлийг нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэлийн сарын мэдээ, улирлын тайланд тусгана.

4. Нийгмийн даатгалын байгууллага нь энэ журмын дагуу төлбөр, тооцоо хийгдсэн тохиолдолд үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тахир дутуугийн тэтгэвэр авагчийн тухайн тэтгэврийг авч байсан хугацааг тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно. Энэ хугацааг тооцох үндсэн баримт нь тэтгэвэр авагчийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас тэтгэвэр авч байсан "тахир дутуугийн тэтгэвэр"-ийн дэвтэр, хөдөлмөрийн чадвар алдалтын шалтгаан, хувь, хугацааг тогтоосон Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын акт байна.